


Нэгтгэлийн Үйл Явц


Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын орлогын төлөлт, 2012



Тайлангийн үр дүнтэй байдлыг сайжруулахын тулд Монголын ОУИТБС Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсэг зөвхөн 40 сая төгрөгөөс дээш төлөлт хийсэн компаниудыг нэгтгэл тайланд хамруулахаар зорьж байна. 2012 онд нийт 471 компани уг шаардлагыг хангасан бөгөөд шаардлага хангасан 200 компанийг нэгтгэл тайланд хамруулсан. Гэвч эдгээр компаниудыг ямар үндэслэлээр сонгож авсан нь тодорхойгүй байна.


Уг нэгтгэл тайланд хамрагдсан компаниуд нь тайланд хамрагдсан компаниудын зөвхөн 13 %-ыг эзэлжээ. 2012 оны ОУИТБС тайланд дурьдсанаар Монголын олборлох үйлдвэрлэлийн салбарын нийт орлого жагсаалт байдлаар гардаггүй бөгөөд энэ нь ОУИТБС тайланд тусгагдсан тоо баримт уг салбараас орох дийлэнх орлогын хэмжээг хамруулж чадаж байгаа эсэхийг тодорхойлоход бэрхшээл учруулж байна. ОУИТБС тайланд тусгагдсан нийт орлогыг бүрдүүлж буй тайланд хамрагдсан 200 компаниудийн 65% -ыг томоохон таван компани, 80 гаруй хувийг томоохон арван компани бүрдүүлсэн байна.

Payments of reconciled companies, 2012



Үйл Ажиллагааны Төрөл

Participation of 200 Reconciled Companies and Contribution by Sectors (2011) (Million MNT)



ОУИТБС нэгтгэл тайланд хамрагдсан 200 компаниуд төрөл бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Хамрагдсан компаниудын дийлэнх нь Хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг. Алт болон нүүрсний олборлолтын үйл ажиллагаа удаах хувийг эзэлнэ.

Төлбөрийн хэмжээг үйл ажиллагааны төрлүүдээр авч үзвэл нүүрсний олборлолт явуулж буй компаниуд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй компаниудаас 2 дахин илүү төлөлт хийдэг байна. Нийт олборлолт явуулж буй компаниудын 25%-г алт олборлож буй компаниуд эзэлж байгаа ч тэдгээрийн нийт төлсөн төлбөрийн эзлэх хувь маш бага байна.

Компаниудын үйл ажиллагааны төрлүүд болон төлсөн төлбөрийн хэмжээнээс харахад нүүрсний салбарт их хэмжээний олборлолт явуулж, засгийн газарт ихээхэн хэмжээний төлбөр төлдөг цөөн тооны компаниуд байгаа нь ажиглагдаж байна. Харин хайгуулын үйл ажиллагаа явуулж буй компаниудын засгийн газарт төлж буй төлбөрийн хэмжээ харьцангуй бага байгаа нь ажиглагдсан бөгөөд энэ нь татвар хураамж/лицензийн төлбөрийн зохицуулалт дутмаг байдлаас шалтгаалжээ.



Төлбөр болон орлогын хэмжээний зөрүү

Зөрүү 2006-2012			(сая төгрөг-р)
Тайлант жил	Компаниуд	Анхны зөрүү	Шийдвэрлэгдээгүй зөрүү
2006	25	-96,827	25,094
2007	38	-23,442	775
2008	46	-47,508	431
2009	101	-266,508	58,2
2010	150	-11,133	0,36
2011	200	-477,553	74,6
2012	200	-150,374	361

Нэгтгэлийн үйл явц үндсэн 3 үе шаттай:

1. Нэгтгэл тайланд хамрагдсан 200 компани төлсөн төлбөрийн хэмжээгээ тайлагнаж, хөндлөнгийн аудитор энэ үед төрийн зүгээс хүлээн авсан орлогын хэмжээнд ямар нэг боломжит алдаа буй эсэхийг илрүүлнэ;
2. Компаниудын хийсэн төлбөр болон төрийн байгууллагуудын хүлээн авсан орлогын хэмжээг ОУИТБС Ажлын Хэсэгт тайлагнана;
3. Гарсан зөрүүнд тохируулга хийж ОУИТБС Ажлын Хэсэг зөвшөөрсний үндсэн дээр эцсийн төлбөр болон орлогын хэмжээ, шийдэгдээгүй үлдсэн зөрүүг тайлагнана.

2012 онд шийдэгдээгүй үлдсэн төлбөрийн зөрүү хэмжээ ойролцоогоор 361 сая төгрөг байсан бөгөөд энэ нь төрийн зүгээс мэдэгдсэнээр нийт төлөлтийн 0.02%-г эзэлж байна. Уг зөрүү үүсэхэд нөлөөлсөн 4 үндсэн шалтгаан байна:

1. Төрийн байгууллагаас тайлагнаагүй татвар;
2. Компаниуд тайлагнаагүй татвар;
3. Олборлох компаниудын зүгээс төлсөн төлбөрийн мэдээллийг орхигдуулах;
4. Компаниуд ОУИТБС тайлан гаргах үүргээ биелүүлээгүй.


ОУИТБС-ын Ажлын Хэсэг нь төрийн болон холбогдох байгууллагуудыг уг төлбөрийн хэмжээний зөрүү гарахад нөлөөлсөн хүчин зүйлүүдийг арилгах, сайжруулах, алдаанаасаа суралцах тал дээр дэмжлэг үзүүлэн анхаарч ажиллаж байна. Гэвч өмнөх ОУИТБС тайлангууд дээр тусгагдсан санал зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй үлдсэн хэвээр байна. Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүү хэмжээ нь төрийн байгууллагуудын хүчин чадал, төлбөр тооцооны төвлөрсөн систем дутагдалтай байдал болон Монгол Улсын татвар, хууль эрх зүйн орчин зэрэг хүчин зүйлээс хамаарч байна. ОУИТБС Үндэсний Зөвлөл болон Засгийн газар тодорхой цаг хугацааны давтамжтай тайланд тусгагдсан санал зөвлөмжүүдийг хамтран хэрэгжүүлвэл уг зөрүү хэмжээг бууруулах боломжтой.



THE UNIVERSITY OF BRITISH COLUMBIA



Орон Нутгийн Оролцоо



Жил бүр аймгийн засаг захиргааны нэгжүүд ОУИТБС Ажлын Хэсэгт олборлох үйлдвэрлэлээс хүлээж авсан орлогын хэмжээг тайлагнах үүрэгтэй.

- 2011 онд аймгуудыг ОУИТБС тайланд хэрхэн оролцож байгаагаар нь үнэлсэн бөгөөд 8 аймаг “сайн”, 5 аймаг “дунд” болон 8 аймаг “муу” гэсэн үнэлгээг авчээ;
- Муу гэсэн үнэлгээг авсан аймгуудад бүрэн бус мэдээлэл явуулах болон тайланг цаг хугацаанд гаргаагүй гэсэн нийтлэг дутагдал ажиглагдсан байна;
- Орон нутгийн оролцоонд удирдлагын тогтолцоо, шаардлагын хөшүүрэг болон иргэдийн чадавхи дутагдаж байна;
- Орон нутгийн оролцоог сайжруулахад ОУИТБС –ын Дэд.

Зөвлөл – Орон нутгийн засаг захиргаа, ТББ болон олборлох үйлдвэрлэлийн компаниудын төлөөллөөс бүрдсэн нутгийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хэрэгтэй.

ОУИТБС Дэд Зөвлөл нь дараах үүрэгтэй:

- ОУИТБС болон олборлох үйлдвэрлэлийн талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах – Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон орон нутгийн захиргааны хоорондын харилцааг олон нийтэд мэдээллэх;
- ОУИТБС үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг иргэний нийгмийн төлөөлөөр болон мэдээллийн хэрэгслээр дамжуулан уриалах;
- Ажлын Хэсгийн харилцаа холбоог сайжруулах.

Орон нутгийн оролцоог сайжруулах арга замууд:

- Сумдуудад ОУИТБС –ын мэдээллийн төвүүдийг байгуулах;
- ОУИТБС тайлангаас чухал хэрэгцээтэй мэдээллүүдийг нэгтгэн эмхтгэл хуудас тараах;
- Олон нийтэд радио, телевиз болон мэдээллийн хэрэгслээр ОУИТБС-ын тухай мэдээлэл түгээх.

вэб сайт: <http://blogs.ubc.ca/maapps/>
и-мэйл: julian.dierkes@ubc.ca

Байгууллагын Нийгмийн Хариуцлага (БНХ)

Компаниуд	Хандив (сая төг)	Нийт төлөлт (сая төг)	Төлбөр байдлаар мэдээлэгдсэн хандив (%)	Хөрөнгө оруулалт
Оюу Толгой	12,357,433	398,358,464	3.10%	Хамтарсан
Бороо Гулд	4,090,698	21,163,320	19.35%	Гадаад
Энержи Ресурс	1,746,535	83,730,687	2.09%	Дотоод
Монголын Алт МАК	1,387,255	158,504,558	0.88%	Дотоод
Бид Төмөр Ерэн Тал	1,266,24	39,990,463	3.17%	Дотоод
Эрдэнэт УБУ	659,605	548,537,404	0.12%	Хамтарсан
Соус Гови Сэнцэ	641,171	64,882,419	0.99%	Гадаад
Монполимет	311,600	5,347,116	5.83%	Дотоод
Петро чайна дачин тамсаг монгол	307,000	59,054,962	0.52%	Гадаад
Мон Эн ко	300,691	3,565,944	8.43%	Гадаад

2011 онд олборлох үйлдвэрлэлийн салбар нийт 26.9 тэрбум төгрөгийн хандив тусламжийг үзүүлжээ. Уг хандив тусламжаар компаниуд орон нутгийн иргэдийг дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сургууль байгуулах, тамирчид болон судлаачдыг дэмжих, жижиг бизнесийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа орно.

Монголд үйл ажиллагаа явуулж буй Монгол болон Гадаад хөрөнгө оруулалттай компаниуд БНХ-ын хүрээнд ижил түвшинд үйл ажиллагаа явуулдаг. Нийт 10 хандив үзүүлэгч томоохон компаний 4 нь үндэсний, 4 нь гадаад, 2 нь хамтарсан удирдлагатай компаниуд байна.

ОУИТБС-ын харилцаа холбоо

Санал зөвлөмж/Урагшлах алхмууд

Монголд ОУИТБС нь 2007 оноос 2013 он хүртэл нийт 7 тайлан, тайлангийн үйл явцийг сайжруулах 70 орчим санал зөвлөмжийг гаргажээ. Гэвч эдгээр санал зөвлөмжүүдээс ихэнх нь бодит байдал дээр хэрэгжиж амжаагүй байна. Санал зөвлөмжүүдийг зөвхөн үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудаас гадна сум, аймаг төрийн захиргааны байгууллагууд болон яамдуудын үйл ажиллагаанд чиглүүлэн аргасан. Эдгээрээс доорх санал зөвлөмжүүдийг цаашид дагаж мөрдөх шаардлагатай:

- Төрийн зүгээс өгч байгаа бүрэн бус мэдээлэл;
- Хандив тусламжийн хэмжээг тайлагнах;
- Гадаад төлбөрийн хэрэгслээс шалтгаалсан төлбөрийн зөрүүнээс зайлсхийх;
- Монголд ОУИТБС-ын албан газар байгуулах;
- Зарим төлбөрийн дүнг анхны нэгтгэлд бүрэн хамруулах, заримыг хасах талаар.

- ОУИТБС-ын ерөнхий үйл явцийг чиглүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг сайжруулах;
- ОУИТБС-ыг олон нийтэд сурталчлах;
- Тайланг удаа дараа гаргаагүй, нэгтгэл тайлангийн ажилд хойрго хандсан компаниудад арга хэмжээ авах талаар

Гол тоо баримтууд

ОУИТБС (Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга) нь дэлхийн олон орон нэгдсэн, Засгийн газар, компани, иргэний нийгмийн эрх тэгш хамтын ажиллагаа бөгөөд байгалийн баялагаас орж ирсэн ашгийн хувиарлалт, нээлттэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн юм. Нэг талаас компаниуд төлсөн татварын дүн хэмжээгээ, нөгөө талаас Засгийн газар нь тэдгээр компаниудаас хүлээн авсан татварын дүнг тайлагнан хоёр талын тайлан гаргах бөгөөд уг тайланг хөндлөнгийн аудитор хянан нэгтгэгдэж нэгдсэн тайлан гаргах ба тайлангийн дагуу бодит арга хэмжээг аван иргэдэд нээлттэй ил тод байлгахад оршино. Монгол улс 7 жилийн турш тайлангаа гаргаж байгаа бөгөөд 2010 онд шаардлагыг бүрэн хангасан орноор хүлээн зөвшөөрөгдсөн.

Олборлох үйлдвэрийн салбар нь Монгол улсын төсвийг бүрдүүлэгч гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ талаар 2010 онд Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газрын мэдэгдснээр Монгол улсын ДНБ-ний 30%, экспортын бүтээгдэхүүний 81% эзэлсэн гэсэн байна. Гол экспортын бүтээгдэхүүнд зэс, алт, молибден, нүүрс, хайлуур жоншны баяжмал зэрэг бүтээгдэхүүнүүд орсон байна. Оюу Толгой зэс алтны уурхайн төсөл нь 2020 он гэхэд ДНБ-ний гуравны нэгийг эзлэнэ гэж урьдчилан тооцоологдсон байна. ОУИТБС хэрэгжүүлснээр байгалын баялагаас орж ирсэн орлогын зохицуулалт, ил тод байдлыг сайжруулах гол үүргийг гүйцэтгэх юм. ОУИТБС тайлан тавих явц нь дэлхий нийтэд ЗГ, компаниуд, иргэний нийгмийн ил тод хариуцлагатай байдалд хүрэх алхам гэж тооцогддог бол Монгол улсын олон талт оролцогчдоод ямар бодитой үр өгөөж өгөх вэ?

Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачлага (ОУИТБС)-ын 2012 оны тайланд тусгаснаар Олборлох үйлдвэрлэлийн салбар дахь ашигт малтмалын лиценз эзэмшигч нийт 1514 компаниудаас Засгийн Газарт татвар, төлбөр төлөгджээ. Үүнд:

- 1503 уул уурхайн компани;
- 8 газрын тосны компани;
- 3 уран олборлох компани тус тус хамрагджээ.

Тайланд хамрагдсан 1822 компаниудын 80 гаруй хувь нь Ашигт малтмалын газарт бэртгэлтэй лиценз эзэмшигчид байна.

Тайлангийн эдгээр баримтууд хэрхэн байгалийн баялгаас орж ирсэн орлогын мэдээллийг олон нийтэд ил тод байлгаж Монгол улсын хүн амын хөгжилд ашиглаж болох вэ? Энэхүү Монгол улсын ОУИТБС-ийн талаархи төсөлд Ази Судлалын Институтын багш профессор Жулиан Дьеркис ба уул уурхайн инженерийн сургуулийн багш профессор Дёрк ван Зил нараар удирдуулсан Бритиш Колумбын Их Сургуулийн магистрын зэрэг горилон суралцагч оюутнууд оролцсон болно. Уг оюутнууд нь Монгол ба Ази-Номхон далайд ажилласан туршлагатай, Ази Номхон далайн бодлогийн талаар мэргэшсэн, уул уурхайн инженер, бүс нутгийн төлөвлөлт, байгалийн нөөц ашиглалт болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр суралцагч оюутнуудын нэгдэл юм.